

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: TWN-2021/001

“ЭЛЭГНИЙ ТӨВ” ЭМНЭЛЭГ

ХЕПАТИТЫН ДЕЛЬТА ВИРҮСИЙГ ИЛРҮҮЛЭХ ТЕХНОЛОГИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ
нэгдсэн сэдвийн хүрээнд

**Шинэ төрлийн LAMP-ПГУ-ын арга зүй
боловсруулж хепатитын Дельта вирусийн
тархвар зүйн судалгаа болон түүнээс
урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд
ашиглах нь
сэдэвт дэд төсөл**

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан
2022-2023

Төслийн хавсран гүйцэтгэгч:	Тайваны Үндэсний Ян-Мин Их Сургууль
Төслийн удирдагч:	Д.НАРАНЖАРГАЛ-доктор (Ph.D), Элэгний төв
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан технологийн сан
Захиалагч байгууллага:	Элэгний төв
Тайлан өмчлөгч:	Элэгний төв. УБ-14230. Юнескогийн гудамж, Далай Цамхаг 2-р давхар. info@livercenter.mn

УЛААНБААТАР ХОТ
2023

РЕФЕРАТ

Монгол улс нь Хепатитын Дельта Вирусийн (ХДВ) тархалт хамгийн өндөртэй, элэгний өвчлөл түүний хүндрэл нэн ялангуяа 100 мянган хүнд ногдох элэгний хавдрын нас баралтын тохиолдол хамгийн өндөр улс болоод байна. Гэвч ХДВ-ийн оношилгоо тийм ч сайн биш, хөдөө орон нутагт хүртээмж муутай байгаа билээ. Иймээс бид ХДВ-ийн халдварыг илрүүлэх ЛАМП (Loop-Mediated Isothermal Amplification) полимеразын гинжин урвал (ПГУ)-ын арга зүйг боловсруулж үнэлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийв. ЛАМП-ПГУ нь өндөр үнэтэй бодит хугацааны полимеразын гинжин урвал (БХ-ПГУ)-ын циклер гэх мэт тусгай тоног төхөөрөмж шаардахгүй тул хөгжиж буй эдийн засаг буурай улс орон, өндөр технологийн хэрэглээ хязгаарлагдмал хөдөө орон нутагт хэрэглэхэд тохиромжтой технологи юм. Бид ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулахын тулд ХДВ-ийн халдвартай болон халдваргүй хүмүүсийг судалгаанд хамруулах шаардлагатай байсан тул уг судалгааг Эрүүл мэндийн яамны анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрөлтэйгээр эхлүүлсэн.

Одоогоор мэдэгдэж буй ХДВ-ийн бүх 8 генотипын геномын дараалалд дүн шинжилгээ хийж хамгийн сайн тогтвортой хадгалагддаг геномын бүсэд 5 өөр багц праймеруудыг зохион бүтээж ПГУ-ыг явуулсан билээ. Багц праймеруудыг эрүүл хүмүүсийн дээжид туршилт хийж хуурамч эерэг (false positive) үр дүнд шүүж тодорхойлод 5-р багц праймер хамгийн сайн байв. БХ-ПГУ-ыг хяналтын арга зүй болгож судалгаанд хамрагдагчдын ХДВ илрүүлэх шинжилгээг хийж баталсан. Улмаар БХ-ПГУ-аар ХДВ халдвартай болон халдваргүй батлагдсан дээжүүдийг ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулахад ашигласан ба ПГУ-ын бүтээгдэхүүнүүдийг агароз гель электрофорез болон диссоциацийн муруйгаар баталгаажуулсан. Өнгө үзүүлэгч болон флуоресценц ЛАМП-ПГУ-ын олшруулалт явагдах температур, хугацаа, мэдрэг болон өвөрмөц шинж чанарыг хэд хэдэн туршилтын үр дүнгээр тодорхойлов. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ыг явуулахад 65 цельсийн градус, флуоресценц ЛАМП-ПГУ-ыг явуулахад 68 цельсийн градусын температурт ХДВ-ийн РНХ-ийг олшруулахад тохиромжтой байсан. Мөн өвөрмөц чанар 100%, мэдрэг чанар 94.4% байв. Бидний одоогоор боловсруулсан ХДВ ЛАМП шинжилгээ нь цусны дээжид ХДВ-РНХ илрүүлэхэд хурдан, хэрэглэхэд хялбар, өндөр мэдрэмжтэй технологи юм хэмээн дүгнэсэн ба цаашид улам сайжруулж хэрэглээнд нэвтрүүлэхийг зорьж байна.

Түлхүүр үг: ХДВ, хепатитын Дельта вирус, ЛАМП-ПГУ, ПГУ, полимеразын гинжин урвал

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД

Дашдорж Наранжаргал	Элэгний төв эмнэлэг	Хүний их эмч, Анагаах ухааны доктор (Ph.D)
Ойдовсамбуу Одгэрэл	Монгол Улсын Их Сургууль	Биологийн ухааны доктор (Ph.D), дэд профессор
Энхжаргал Саруул	Монгол Улсын Их Сургууль	Инженерчлэлийн ухааны магистр
Ренчиндорж Бишгүүрмаа	Элэгний төв эмнэлэг	Анагаах ухааны магистр
Бат-Өлзий Пүрэвжаргал	Элэгний төв эмнэлэг	Анагаах ухааны магистр

ГАРЧИГ

РЕФЕРАТ.....	II
СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД	III
НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	VIII
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	X
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	XI
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	XII
УДИРТГАЛ.....	1
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ	1
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	3
СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ, ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ	3
БҮЛЭГ 1. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ-ОНОЛЫН ХЭСЭГ	5
1.1. ХЕПАТИТ ВИРҮСҮҮД	5
1.2.1.ХЕПАТИТ ДЕЛЬТА ВИРҮС	5
1.2.2. Хепатит Дельта вирусийн бүтэц.	6
1.2.3. Хепатит Дельта вирусийн антиген	7
1.2.4. Хепатит Дельта вирусийн генотип ба тархалт	8
1.3. ХЕПАТИТ ДЕЛЬТА ВИРҮСИЙН ОНОШИЛГООНЫ АРГУУД	10
1.3.1. Серелогийн оношилгооны арга	10
1.4.2. Молекул оношилгооны арга	11
1.4. ЛАМП (LAMP-LOOP MEDIATED ISOTHERMAL AMPLIFICATION) ПОЛИМЕРАЗЫН ГИНЖИН УРВАЛ	13
1.4.1. ЛАМП-ПГУ-ын ажиллах зарчим.....	13
1.4.2. ЛАМП-ПГУ-ын үе шат.....	14
1.4.3. Колориметрик буюу өнгө үзүүлэгч ЛАМП полимеразын гинжин урвал ...	15
1.4.4. Флуоресценц ЛАМП полимеразын гинжин урвал	17
1.4.5. ЛАМП-ПГУ-ын хязгаарлагдмал тал	18
БҮЛЭГ 2. ТУРШИЛТЫН ХЭСЭГ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	19
2.1. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ.....	19

2.1.1. Судалгааны ёс зүйн зөвшөөрөл.....	19
2.1.2. Судалгааны дээж	19
2.1.3. Химийн бодисууд	19
2.1.4. Буффер, уусмал.....	19
2.1.5. Судалгаанд ашигласан цомгууд.....	20
2.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	20
2.2.1. ХДВ-ийн геномын дарааллын анализ.....	20
2.2.2. ЛАМП-ПГУ-ын праймер боловсруулалт	20
2.2.3. ХДВ-ийн нуклейн хүчил ялгах	20
2.2.4. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ	21
2.2.5. ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулах.....	22
2.2.6. Агароз гель электрофорез.....	23
БҮЛЭГ 3. ҮР ДҮН.....	24
3.1. ХДВ-ийн геномын дарааллын анализ	24
3.2. ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын праймер загварчлалын үр дүн.....	25
.....	27
3.3. Бодит хугацааны полимеразын гинжин урвалын үр дүн	27
3.3.1. БХ-ПГУ-аар ХДВ-РНХ дараалсан шингэрүүлгийг бэлдсэн нь.....	27
3.3.2. ХДВ-ийн халдварыг тоон БХ-ПГУ-аар илрүүлэн баталж, тоолсон туршилтын үр дүн.....	28
3.3.3. ХДВ-ийн халдваргүй буюу эрүүл хүмүүсийг БХ-ПГУ-ын туршилтаар баталсан үр дүн.....	29
3.2. Өнгө үзүүлэгч ЛАМП полимеразын гинжин урвалын үр дүн.....	31
3.2.1. ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын багц праймеруудын харьцуулсан үр дүн	31
3.2.2. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаарыг тодорхойлсон үр дүн.....	31
3.2.3. ХДВ-РНХ-ийг өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-аар илрүүлсэн үр дүн	32

3.2.4. ХДВ-ийн халдваргүй эрүүл бүлэгт өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ыг туршсан үр дүн.....	32
3.3. Флуоресценц ЛАМП полимеразын гинжин урвалын үр дүн	33
3.3.1.ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын тохиромжтой температурын нөхцөлийг тодорхойлсон үр дүн.....	33
3.3.2. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаарыг тодорхойлсон үр дүн.....	35
3.3.3. ХДВ-РНХ-ийг флуоресценц ЛАМП-ПГУ-аар илрүүлсэн үр дүн	37
3.3.4. ХДВ-ийн халдваргүй эрүүл бүлэгт флуоресценц ЛАМП-ПГУ-ыг туршсан үр дүн.....	38
3.3.5.Флуоресценц ЛАМП-ПГУ-ын арга зүйгээр РНХ ялгалгүйгээр цусны ийлдэснээс ХДВ-ийг илрүүлсэн үр дүн.....	40
3.4. Агароз гель электрофорезын үр дүн.....	41
3.5. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын бүтээгдэхүүнийг хөх туяаны гэрлээр шалгасан үр дүн	42
ДҮГНЭЛТ	44
АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭШЛЭЛ	45
А ХАВСРАЛТ. Судалгааны ёс зүйн зөвшөөрөл.....	50
Б ХАВСРАЛТ. ХДВ-ийн ДЭМБ-ын стандарт	51
В ХАВСРАЛТ. БХ-ПГУ-ын түүхий өгөгдөл.....	53
В.1. БХ-ПГУ-аар ХДВ-РНХ дараалсан шингэрүүлгүүд.....	53
В.2. ХДВ-РНХ-ийг тоон БХ-ПГУ-аар тоолсон.....	55
В.3. ХДВ-ийн халдваргүй эрүүл дээжүүдийг БХ-ПГУ-аар баталсан.....	59
Г ХАВСРАЛТ. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын түүхий өгөгдөл.....	63
Г.1.2. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 65°C дэх диссоциацын муруйн өгөгдөл	65
Г.2.1. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 68°C дэх олшруулах муруйн өгөгдөл	68
Г.2.2. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 68°C дэх диссоциацын муруйн өгөгдөл	69

Г.3.1. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаарын олшруулах муруйн өгөгдөл	72
Г.3.2. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаарын диссоциацийн муруйн өгөгдөл	74
Г.4.1. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын ХДВ-ын халдварыг илрүүлсэн олшруулах муруйн өгөгдөл	77
Г.4.2. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын ХДВ-ын халдварыг илрүүлсэн диссоциацийн муруйн өгөгдөл	79
Г.5.1. Флуоресценц ЛАМП-ПГУ-ыг эрүүл бүлэгт туршсан олшруулах муруйн өгөгдөл	85
Г.5.2. Флуоресценц ЛАМП-ПГУ-ыг эрүүл бүлэгт туршсан диссоциацийн муруйн өгөгдөл	89
Д ХАВСРАЛТ. Олон улсын сэтгүүлд хэвлэгдсэн хураангуй.....	98
Е ХАВСРАЛТ. Судалгааны хүрээнд боловсруулсан зөвлөмж.....	99
Хепатитын Дельта вирүсийн халдварын тархалт, өвчний хүндрэлийг бууруулах чиглэлд авах цогц арга хэмжээний талаарх зөвлөмж	99

НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

°C	Celsius (Цельс)
Ab	Antibody (Эсрэг бие)
Ag	Antigen (Антиген)
BIP	Backward inner primer (Урвуу дотоод праймер)
CCD	Coiled coil domain (Цагирагласан домайн)
CMV	Cytomegalovirus (Цитомегало Вирус)
ddH ₂ O	double-distilled water (Давхар нэрсэн ус)
EDTA	Ethylenediaminetetraacetic acid (Этилендиаминететрацетик хүчил)
ELISA	Enzyme linked immunosorbent assay (Энзим холбоот эсрэг биеийн урвал)
FIP	Forward inner primer (Шууд дотоод праймер)
HBsAg	Hepatitis B surface antigen (Хепатитын В вирусийн гадаргуугийн антиген)
HCl	Hydrochloric acid (Давсны хүчил)
HDAg	Hepatitis D antigen (Хепатитын D антиген)
HPV	Human papillomavirus (Хүний хөхөнцөр Вирус)
HSV	Herpes simplex virus (Энгийн херпесийн Вирус/ хомхой)
IFN	Interferon (Интерферон)
IgG	Immunoglobulin G (Иммуноглобулин G)
IgM	Immunoglobulin M (Иммуноглобулин M)
IU	International Unit
LB	Loop backward primer (Гогцоот урвуу праймер)
LF	Loop forward primer (Гогцоот шууд праймер)
NSL	Nuclear localization signal (Цөмийн төвөөс сигнал өгөх домайн)
NTCP	(Натрийн тауохлораттай хавсарган зөөвөрлөгч полипептид)
ORF	Open reading frame (Нээлттэй унших хүрээ)
RBD	RNA-binding domains (РНХ холбогч домайн)

RIA	Radioimmunoassay (Радиоиммун шинжилгээ)
TBE	Tris-borate-EDTA
БХ-ПГУ	Бодит хугацааны полимеразын гинжин урвал Real-Time polymerase chain reaction
г	Грамм (Gram/g)
ДНХ	Дизоксирибонуклейн хүчил (Deoxyribonucleic acid/DNA)
кДНХ	комплементар дизоксирибонуклейн хүчил (complementary DNA/cDNA)
л	Литр (Liter/L, l)
ЛАМП	Loop-Mediated Isothermal Amplification
М	Моль (Mole/M)
мин	Минут (Minute/min)
мкл	Микролитр (Microliter/ μ L)
мкм	Микрометр (Micrometer/ μ m)
мл	Миллилитр (Milliliter/mL)
мМ	Миллимоль (Millimole/mM)
ПГУ	Полимеразын гинжин урвал (Polymerase chain reaction/PCR)
РНХ	Рибонуклейн хүчил (Ribonucleic acid/RNA)
сек	Секунд (Secund/sec)
х.н	Хос нуклеотид (base pair/bp)
ХАВ	Хепатит А вирус (Hepatitis A virus)
ХБВ	Хепатит В вирус (Hepatitis B virus)
ХДВ	Хепатит D вирус (Hepatitis D virus)
ХЕВ	Хепатит E вирус (Hepatitis E virus)
ХЦВ	Хепатит C вирус (Hepatitis C virus)
ц	Цаг (Hour/h)

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хүний цусны ийлдэс дэх Д вирусийн электрон микроскопоор харагдах байдал.....	6
Зураг 2. ХДВ болон ХБВ бүтэц.....	7
Зураг 3. ХДВ-ийн геном	7
Зураг 4. ХДВ транскрипцийн өөрчлөлтүүд болон байршил	8
Зураг 5. ХДВ-ийн тархалт.....	9
Зураг 6. БХ урвуу транскриптаза ПГУ-ын үе шат	12
Зураг 7. Бодит хугацааны ПГУ-ын явц	13
Зураг 8. ЛАМП полимеразын гинжин урвалын үе шат, механизм	15
Зураг 9. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ын схем	16
Зураг 10. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын схем.....	17
Зураг 11. ХДВ-ийн геномын дараалал	24
Зураг 12. ЛАМП-ПГУ-ын багц праймеруудын ХДВ-ийн геном дээрх байрлал.....	27
Зураг 13. ЛАМП-ПГУ-ын багц праймеруудын харьцуулалт	31
Зураг 14. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаар.....	31
Зураг 15. ХДВ-ийн халдварыг өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-аар илрүүлсэн үр дүн.....	32
Зураг 16. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ыг эрүүл бүлэгт туршсан үр дүнг.....	32
Зураг 17. ЛАМП-ПГУ-ын бүтээгдэхүүний агароз гель электрофорезын үр дүн.....	42
Зураг 18. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын бүтээгдэхүүнийг UV гэрлээр шалгасан үр дүн	43

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ХДВ-ийг илрүүлэх оношилгооны аргууд	2
Хүснэгт 2. ХДВ-ийг илрүүлэх Wang et al, -ийн болон бидний судалгааны ялгаатай талууд	2
Хүснэгт 3. Хепатит вирусийн ялгаатай шинж чанарууд	5
Хүснэгт 7. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын праймер болог пробын дараалал	21
Хүснэгт 8. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын мастер холимог	21
Хүснэгт 9. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын нөхцөл.....	21
Хүснэгт 10. ЛАМП-ПГУ-ын праймеруудын холимог.....	22
Хүснэгт 11. ХДВ-ийг илрүүлэх өнгө үзүүлэх ЛАМП-ПГУ-ын мастер холимог.....	22
Хүснэгт 12. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын мастер холимог.....	23
Хүснэгт 13. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын нөхцөл	23
Хүснэгт 14. ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын багц праймеруудын дараалал.....	25
Хүснэгт 15. ХДВ-РНХ-ийн шингэрүүлэгийн БХ-ПГУ-аар илрүүлсэн үр дүн.....	27
Хүснэгт 16. ХДВ-РНХ-ийг тоон БХ-ПГУ-аар тоолсон үр дүн	29
Хүснэгт 17. ХДВ-ийн халдваргүй эрүүл дээжүүдийг БХ-ПГУ-аар баталсан үр дүн .	30
Хүснэгт 18. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 65 °С дэх үр дүн.....	33
Хүснэгт 19. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 68 °С дэх үр дүн.....	34
Хүснэгт 20. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаар	36
Хүснэгт 21. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын ХДВ-ийн халдварыг илрүүлсэн үр дүн....	37
Хүснэгт 22. Флуоресценц ЛАМП-ПГУ-ыг эрүүл бүлэгт туршсан үр дүн	39
Хүснэгт 23. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын ХДВ-РНХ болон халдвартай ийлдэсний илрүүлгийн үр дүн.....	40

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. ХДВ-РНХ-ийн дараалсан шингэрүүлгийн БХ-ПГУ-ын олшруулах муруй	28
График 2. ХДВ-РНХ-ийн дараалсан шингэрүүлгийн БХ-ПГУ-ын стандарт муруй ...	28
График 3. ХДВ-РНХ-ийг тоон БХ-ПГУ-ын олшруулах муруй	29
График 4. ХДВ-ийн халдваргүй эрүүл дээжүүдийг баталсан БХ-ПГУ-ын олшруулах муруй	30
График 5. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 65 °С дэх олшруулах муруй	34
График 6. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 65 °С дэх диссоциацийн муруй	34
График 7. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 68 °С дэх олшруулах муруй	35
График 8. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын 68 °С дэх диссоциацийн муруй	35
График 9. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаарын олшруулах муруй	36
График 10. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын илрүүлэх доод хязгаарын диссоциацийн муруй	36
График 11. ХДВ-ийн халдварыг илрүүлсэн флуоресценц ЛАМП-ПГУ-ын олшруулах муруй	37
График 12. ХДВ-ийн халдварыг илрүүлсэн флуоресценц ЛАМП-ПГУ-ын диссоциацийн муруй	38
График 13. ХДВ-ийн халдваргүй эрүүл бүлэгт туршсан флуоресценц ЛАМП-ПГУ-ын олшруулах муруй	38
График 14. ХДВ-ийн халдваргүй эрүүл бүлэгт туршсан флуоресценц ЛАМП-ПГУ-ын диссоциацийн муруй	39
График 15. ХДВ-РНХ болон халдвартай ийлдэсний флуоресценц ЛАМП-ПГУ-ын диссоциацийн муруй	41
График 16. ХДВ-РНХ болон халдвартай ийлдэсний флуоресценц ЛАМП-ПГУ-ын олшруулах муруй	41

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Хепатитын Дельта вирус нь (ХДВ) хепатитын Б вирус (ХБВ)-ийн гадаргуугийн антигенийн тусламжтайгаар цааш үржих боломжтой болдог, дангаараа халдвар үүсгэх чадваргүй вирус юм [1]. ХДВ-ийн халдвар нь хепатитын вирусүүд дотроос хамгийн хүнд хэлбэрийн өвчлөлийг үүсгэдэг. Уг вирусийн архаг халдвар маш давшингүй явцтай ба элэгний өвчний хүндрэл болох элэгний хорт хавдар болон хатууралд богино хугацаанд хүргэдэг. ХДВ-ийн тархалтын талаарх тооцоо өнөөг хүртэл маргаантай байгаа бөгөөд ХБВ-ийн халдвартай хүмүүсийн дунд хийгдсэн ХДВ-ийн тархалтыг үнэлэх 95 орны 282 судалгаагаар дэлхийд нийтдээ 15-20 сая хүн ХДВ халдвартай гэсэн тооцоо гарсан бол үүнтэй зэрэгцэн судлагдсан 61 орны 182 судалгаанд хийсэн мета-анализаар 62-72 сая хүн ХДВ халдвартай хэмээсэн статистик тоог гаргажээ [2, 3]. Харин 2010-2019 оны хооронд хийгдсэн судалгаануудын нэгтгэлээр Монгол улсын нийт хүн амын 8.03 (5.26-12.08) хувь буюу 239 (157-360) мянган хүн ХДВ-ийн халдвартай гэж тооцоолсон байна [4–7]. Мөн Монгол улс нь элэгний өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын тоогоор дэлхийд нэгдүгээрт эрэмбэлэгдэж байна [7, 8]. ХДВ-ийг эмчлэх үр дүнтэй эмчилгээ одоогоор байхгүй бөгөөд эрт илрүүлэх шинжилгээг хийж элэгний өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Одоогоор дэлхийд ХДВ-ийг вирусийн эсрэгбие болон эсрэгтөрөгчийг илрүүлэх ийлдэс судлал буюу серологийн аргаар мөн вирусийн РНХ-д суурилсан молекулын оношилгоогоор илрүүлж байна [9]. Хүснэгт 1-т дээр дурдсан аргуудыг харьцуулан харуулав. Шинэ үеийн ЛАМП-ПГУ нь молекул оношилгооны нэгэн төрөл бөгөөд уламжлалт ПГУ-тай харьцуулахад өндөр мэдрэмтгий, тусгай багаж болон мэргэжилтэн шаардахгүй, усан ванн эсвэл дулааны блокийн төхөөрөмж ашиглан хэрэглэж болохуйц, хурдан, хялбар хэрэглээтэй технологи юм [10]. Тус технологи нь маш өвөрмөц бөгөөд ПГУ-аар нэг сая хувь олшруулсан ДНХ-ийн хэмжээг нэг цагийн дотор тэрбум хувь хүртэл нэмэгдүүлдэг [10]. ЛАМП-ПГУ нь тодорхой праймер шаарддаг бөгөөд зорилтот дараалал бүрт урвалын нөхцлийг сайтар оновчтой болгох шаардлагатай, мөн олшруулалтын дараах салгах үе шат байхгүй тул бохирдолд илүү өртөмтгий байх магадлалтай [11]. Одоогоор ХДВ-ийн ЛАМП арга зүйг боловсруулсан **“Wang et al, Development of a reverse transcription-loop-mediated isothermal amplification (RT-LAMP) system for rapid detection of ХДВ**

genotype 1”[12] нэрээр хэвлэгдсэн зөвхөн ганц судалгааны өгүүлэл байна (**Хүснэгт 2**).

Хүснэгт 1. ХДВ-ийг илрүүлэх оношилгооны аргууд [13]

Шинжилгээ	Илрүүлэх арга	Ач холбогдол
Ийлдэс дэх HDAg	Цусны ийлдэснээс ХДВ-ийн эсрэгбиеийг	Анхдагч халдварыг илрүүлнэ. Эсрэгбиеийн хариу урвал үүсгэж чадахгүй байгаа дархлаа суларсан өвчтөнүүдэд хэрэгтэй
Anti-HD IgM	Вирүсийн халдварын эсрэг цусан дахь IgM өвөрмөц эсрэгбиеийг	Цочмог болон архаг идэвхтэй халдварыг илрүүлнэ
Anti-HD IgG	Вирүсийн халдварын эсрэг цусан дахь IgG өвөрмөц эсрэгбиеийг	Одоогийн болон өнгөрсөнд халдварласан халдварыг илрүүлнэ
ХДВ RNA PCR (qualitative)	Цусны ийлдэснээс ХДВ-ийн нуклейн хүчлийг	Идэвхтэй байгаа халдварыг илрүүлнэ. Оношилгоонд тустай
ХДВ RNA PCR (quantitative)	Цусны ийлдэснээс ХДВ-нуклейн хүчлийн хэмжээг тодорхойлно	Идэвхтэй байгаа халдварыг илрүүлнэ. Оношилгоо болон эмчилгээг хянахад тустай

Хүснэгт 2. ХДВ-ийг илрүүлэх судалгааны ялгаатай талууд

	Давуу тал	Сул тал
Wang et al,	<ul style="list-style-type: none"> Судалгаанд хамрагдагч 58 хүн 	<ul style="list-style-type: none"> ХДВ-ийн 1-р генотипийн дараалалд тулгуурлаж ПГУ-ыг явуулсан Агарозын гель электрофорез болон SYBR green бодисыг ПГУ-ын бүтээгдэхүүнд нэмж үр дүнг харсан Мэдрэг чанарыг нийт нуклейн хүчлийн массийн хэмжээ дээр үндэслэж тооцсон
Манай судалгаа	<ul style="list-style-type: none"> ХДВ-ийн бүх 8 генотипийн хамгийн хадгалагдсан дараалал дээр ПГУ-ыг явуулсан Шууд нүдээр үнэлэх колориметрик болон БХ-ПГУ-ын багаж ашиглан бодит хугацаанд вирүсийг илрүүлэх флуоресценц арга зүй ашигласан Мэдрэг чанарыг шууд молекулын тоо дээр үндэслэсэн 	<ul style="list-style-type: none"> Судалгаанд хамрагдагч 23 хүн

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-д нэгдсэн гишүүн бүх улс орнууд 2016-2030 оны хооронд дэлхийн дахинд шинээр гарч буй хепатитын халдварын тохиолдлыг 90%, нас баралтыг 65% бууруулах зорилгыг дэвшүүлсэн билээ [14]. Монгол улсын Засгийн газар дээрх зорилгод нэгдэхийн сацуу манай хүн амд өргөн тархаж элэгний хатуурал, элэгний хавдрын гол шалтгаан гол буй вирүст хепатитыг бууруулах, халдвар дамжих замыг таслан зогсоох зорилгоор “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 90 гаруй мянган хүнийг хепатитын Б вирүсийн халдвартай болохыг оношлоод байна. Манай улсад одоо хэрэгжиж буй эмнэлзүйн удирдамжаар хүнийг хепатитын Б вирүсийн халдвартай хүмүүсийг хепатитын дельта вирүсийн халдварын илрүүлэг оношилгоонд заавал хамруулахаар заасан байдаг боловч энэ нь одоогоор бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа билээ. Энэ нь оношлуур, шинжилгээний хүртээмж, үнэ өртөгтэй холбоотой байгаа юм. Иймээс ч энэхүү судалгааны хүрээнд шинэ аргачлал боловсруулахаар зорьсон ба уг ЛАМП-ПГУ-ын арга зүйг хэрэглээнд нэвтрүүлснээр ХДВ-ийн архаг халдвартай байгаа хүнийг хямд өртгөөр илрүүлэн эмчилгээнд хамруулах, цаашлаад элэгний хатуурал, хорт хавдрыг эрт үед нь оношлох, эмчлэх, тархалтыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ХДВ-ийг илрүүлэх ЛАМП (Loop-Mediated Isothermal Amplification) полимеразын гинжин урвалын технологийн арга зүйг боловсруулж үнэлнэ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан.

Зорилтууд:

1. Хепатитын Дельта вирүсийн халдвартай болон халдваргүй хүмүүсийг судалгаанд хамруулж, дээж материалыг цуглуулна
2. ЛАМП полимеразын гинжин урвалын арга зүйг боловсруулна
3. Хепатит Дельта вирүсийг илрүүлэх ЛАМП полимеразын гинжин урвалын мэдрэг болон өвөрмөц чанарыг үнэлнэ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ, ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ

Японы эрдэмтэн Notomi et al, 2000 онд анх зорилтод ДНХ-ийн дарааллыг хямд бөгөөд мэдрэг чанар өндөртэйгөөр олшруулах ЛАМП-ПГУ-ын технологийг боловсруулсан [14]. ЛАМП-ПГУ-ын технологийн хөгжил цаг хугацаа өнгөрөх тусам сайжирч хөгжүүлэгдсээр хэд хэдэн өвчин үүсгэгчдийн халдварыг илрүүлж, зарим улсын хэрэглээнд аль хэдийн нэвтэржээ. Харин ХДВ-ийн халдварыг илрүүлэх “С.

Wang et al, Development of a reverse transcription-loop-mediated isothermal amplification (RT-LAMP) system for rapid detection of ХДВ genotype 1” ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулсан өгүүлэл 2012 онд “Applied Microbiology” сэтгүүлд хэвлэгдсэн байна. Тус ХДВ-ийг илрүүлэх судалгааны ажлын арга зүйг өөрсдийн боловсруулсан арга зүйтэй харьцуулж давуу болон сул талыг **Хүснэгт 2**-д харуулсан билээ.

Бидний боловруулсан арга зүй, судалгаанаас өөр ХДВ-ийг илрүүлэх өнгө үзүүлэгч колориметрик болон бодит хугацаанд вирүсийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын эрдэм шинжилгээний өгүүлэл, мэдээлэл одоогоор байхгүй байна. Түүнчлэн Монгол улсад анх удаа ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулж байгаа нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал юм.

ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын арга зүйг хэрэглээнд нэвтрүүлснээр түргэн хугацаанд, хямд өртгөөр вирүсийн халдварыг илрүүлэхээс гадна лабораторийн хязгаарлагдмал орчинд шинжилгээг гүйцэтгэж болох учир алслагдмал аймаг, сум, дүүргийн иргэд цаг алдалгүйгээр вирүсийн илрүүлэх шинжилгээг хийлгэх бүрэн боломжтой юм.

БҮЛЭГ 1. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ-ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. ХЕПАТИТ ВИРҮСҮҮД

Вирүст хепатитууд нь элэгийг гэмтээгч вирус бөгөөд өнөөгийн байдлаар А, Б, Ц, Д, Е (ХАВ, ХБВ, ХЦВ, ХДВ, ХЕВ) зэрэг хэдэн төрлийн вирус тогтоогдоод байна [15]. Эдгээр вирусүүд нь өөр өөр замаар олон зуун сая хүнд халдварлаж элэгний архаг өвчинд хүргэдэг бөгөөд урт хугацаандаа элэгний хатуурал, элэгний хорт хавдар зэрэг хүндрэлд хүргэдэг ба вирүст хепатит нь дэлхий дахинд ДОХ, сүрьеэ зэргээс ч илүүтэй нас баралтын хамгийн түгээмэл шалтгаан болж байна [16]. ХАВ, ХБВ, ХЦВ, ХЕВ дөрөв нь дангаараа халдвар үүсгэх чадвартай бол ХДВ нь дангаар халдварлах чадваргүй. Тиймээс ХДВ-ийг согогтой (defective) вирус хэмээх нь бий [1]. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-д нэгдсэн гишүүн бүх улс орнууд 2016-2030 оны хооронд дэлхийн хепатитын халдварыг 90%, нас баралтыг 65% бууруулах зорилгыг ДЭМБ баталсан [17].

Хүснэгт 3. Хепатит вирусийн ялгаатай шинж чанарууд [15, 16]

Шинж чанар	ХАВ	ХБВ	ХЦВ	ХДВ	ХЕВ
Овог	<i>Picornaviridae</i>	<i>Hepadnaviridae</i>	<i>Flaviviridae</i>	<i>Deltaviridae</i>	<i>Hepeviridae</i>
Төрөл	<i>Hepatitis A virus</i>	<i>Orthohepatitis B virus</i>	<i>Hepatitis C virus</i>	<i>Delta virus</i>	<i>Orthohepatitis E virus</i>
Геном	Дан утаслаг РНХ	Хэсэгчилсэн, хос утаслаг ДНХ	Дан утаслаг РНХ	Дан утаслаг РНХ	Дан утаслаг РНХ
Геномийн урт (нуклеотид)	7500	3200	9600	1700	7200
Генотип	6	10 (А-Ј)	8 (1-8)	8 (1-8)	8 (1-8)
Халдварлах зам	Ахуйн замаар	Биеийн шингэн, цус болон бэлгийн замаар	Цусаар	Биеийн шингэн болон цусаар	Цус сэлбэх болон ам, өтгөнөөр
Урьдчилан сэргийлэх	Идэвхижүүлээгүй вакцин	Рекомбинант вакцин	Байхгүй	ХБВ-ийн вакцин	Байхгүй


1.2.1. ХЕПАТИТ ДЕЛЬТА ВИРУС

1977 онд Италийн эрдэмтэн Марио Риззетто ХБВ-ийн халдвартай өвчтөнүүдэд элэгний эсийн шинжилгээ хийж байх явцдаа ХДВ-ийг анх илрүүлсэн ба эхэн үедээ


ХДВ-ийн шинэ серелогийн тэмдэг гэж үзэж байсан ч Шимпанзед туршилт хийхэд ХДВ-ийн антиген болон ХБВ нь хоорондоо холбоотой болохыг тодорхойлсон [1]. ХДВ нь ХБВ-ийг дагалдах ба биологийн зарчмын үндэслэлд ХБВ-ийн халдвар аваагүй тохиолдолд ХДВ-ээр халдварлах боломжгүй юм [18]. 1986 онд ХДВ-ийг анхны цагариг РНХ геномтой амьтны вирус хэмээн тодорхойлсон ба өмнө нь зөвхөн ургамлын вирусээс л цагариг бүтэцтэй РНХ нуклеотидыг илрүүлдэг байжээ [18, 19]. Амьтны ХДВ нь ургамлын вирус болон вирусийн РНХ-тэй хэмжээ болон хоёрдогч бүтэцтэй ихээхэн төстэй байсан тул ургамлаас үүдэлтэй байх магадлалтай хэмээн таамагласан [19]. ХДВ халдварыг ХБВ-тэй хамт (хавсарсан халдвар) эсвэл ХБВ-ийн халдвар авсны дараа ХДВ-ийн халдвар авах (супер-халдвар) гэж хоёр ангилдаг [19]. ХДВ нь вирусийн таксономийн олон улсын хороонд *Deltaviridae*-овгийн цорын ганц төлөөлөгч, *Deltavirus*-ийн төрөл, сээр нуруутны шинэ вирусийн зүйл хэмээн бүртгэгдсэн [1]. ХДВ нь виรอยд, вирусойд болон өвчин үүсгэгчид (патоген)-тэй репликаци болон бүтцээрээ нэлээд төстэй боловч өөр төрөлд ангилагддаг [1, 18].

1.2.2. Хепатит Дельта вирусийн бүтэц.

ХДВ нь гадаргуудаа ХБВ-ийн антиген (HBsAg)-ийг агуулсан байх бөгөөд цөм нь рибонуклейн хүчлээс тогтсон байна [18, 19]. ХДВ нь одоогоор амьтанд мэдэгдэж буй хамгийн жижиг РНХ нуклеотидтай вирус бөгөөд түүний геном нь дан утаслаг бүхий цагариг РНХ-ийн молекулыг агуулсан, сөрөг туйлшралтай, 1700 орчим нуклеотидоос бүрдсэн 36-37 нм диаметр бүхий вирус юм [20]. Их хэмжээний G болон C агуулдаг тул тэдгээрийн нөлөөгөөр нуклеотидын бараг 74% дангаараа ХДВ-ийн антиген (HDAg) саваа хэлбэр бүхий хоёрдогч бүтцийг үүсгэнэ [21].




Зураг 1. Хүний цусны ийлдэс дэх Д вирусийн электрон микроскопоор харагдах байдал [22].



Зураг 2. ХДВ болон ХБВ бүтэц [23].


1.2.3. Хепатит Дельта вирусийн антиген

Вирүсийн геном тус бүр нь 200 орчим HDAg агуулдаг. HDAg нь ХДВ-д кодлогдсон цорын ганц фосфопротейн уураг бөгөөд хоорондоо ижил төсөө бүхий ялгаатай хоёр хэлбэрийн антигенийг агуулах ба нэг нээлттэй хүрээ (ORF)-ээс нийлэгждэг [24]. Эдгээр хоёр ялгаатай хэлбэр нь 195 амин хүчлийн дарааллаас тогтсон 24кДа бүхий ХДВ-ийн жижиг антиген (HDAg-S), 214 амин хүчлийн дарааллаас тогтсон 27кДа бүхий ХДВ-ийн том антиген (HDAg-L) юм [25]. HDAg-L С-терминал бүс дэх 19-20 амин хүчлийг эс тооцвол эдгээр хоёр төрлийн уураг нь хоорондоо ялгаагүй [26]. Харин амьдралын циклийн сүүл үед HDAg-S уураг кодолсон мРНХ дээрх UAG stop кодон эзэн эсийн ADAR1 катализаторын нөлөөгөөр триптофан амин хүчил кодлодог UGG кодон болон өөрчлөгддөг [26, 27]. Нэг ORF-ээс үүссэн HDAg-S ба HDAg-L уургууд амин хүчлийн дарааллаараа 90 хувь ижил байдаг [26, 27].



Зураг 3. ХДВ-ийн геном. Ногоон өнгөөр Дельта рибозимуудыг, хайчаар хуваагдах бүсийг, улаанаар Дельта антиген (HDAg) нээлттэй унших хүрээ (ORF)-г, 1630 байрлал дээрх сум нь түүний транскрипц эхлэх байрлалыг тус тус илэрхийлэх ба ORF дэх X нь HDAg-S-ийн төгсгөлөг кодон ADAR-1 засварлах байршлыг төлөөлнө [26].

ХДВ-ийн хоёр антиген нь хоёул ижил хэлбэрийн функциональ домаинтай байдаг. Үүнд PHX-тэй холбогдсон домайн (RBD), цөмийн төвөөс сигнал өгөх домайн (NLS), цагаригласан домайн (CCD) мөн Глицин болон Пролин амин хүчлээр баялаг С-терминал багтана [27]. HDAg-L 19-20 амин хүчлүүд нь бусад генотипийн өвөрмөц болон хувьсагч дарааллуудыг цуглуулах сигнал болж өгдөг. HDAg-L нь цөмийн экспортын домайн, пренилжих байрлал болон HDAg-тэй холбогдох оролцдог [27]. Вирусийн антигенүүд нь метилжих, ацетилжих, фосфоржих, HDAg-L нь уураг изопренилжих зэрэг хэд хэдэн транскрипцийн өөрчлөлтүүдийг хийдэг [28]. Метилжилт Arg13-аар амин хүчил, ацетилжилт Lys72-аар амин хүчил, фосфоржилт Ser177 ба Ser123-аар амин хүчил дээр тус тус явагддаг [28]. Эдгээр транскрипцийн өөрчлөлтүүд нь HDAg-L репликацийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой [26]. HDAg-S антиген нь PHX репликацийг дэмждэг бол HDAg-L нь вирусийг PHX-тэй угсрах өдөөгч нь болдог.




Зураг 4. ХДВ транскрипцийн өөрчлөлтүүд болон байршил. P-фосфоржих, M-метилжих, A-ацетилжих. HDAg нь метилжих, ацетилжих, фосфоржих зэрэг хэд хэдэн транскрипцийн өөрчлөлтүүдийг хийдэг. Эдгээр өөрчлөлтүүд нь вирусийн PHX репликацийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой. HDAg-S нь PHX репликацийг дэмждэг бол HDAg-L нь вирусийг PHX-тэй угсрах өдөөгч нь болдог [27].

1.2.4. Хепатит Дельта вирусийн генотип ба тархалт

2015 онд дэлхийн хүн амын 3.5% буюу 250 сая гаруй хүн ХБВ-ийн халдвартай хэмээх тооцоог Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (ДЭМБ) гаргажээ. ХБВ-ийн халдвартай хүмүүсийн дунд ХДВ-ийн тархалт 5%-ийг эзлэх бөгөөд энэ нь дэлхий даяар 13 сая хүн ХДВ-ийн халдвартай гэсэн үг юм [2]. Гэхдээ сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн тойм мэдээллүүдэд ХДВ-ийн халдварын тархалтыг тооцоолсон үр дүн янз бүр байна [29]. 1977-2018 онуудын судалгаанд мета анализ хийхэд ХБВ-ийн халдвартай хүн амын дунд ХДВ-ийн тархалт 10.07 орчим хувь буюу дэлхий даяар 74 сая орчим хүн ХДВ-ийн халдвартай гэсэн тооцоо байсан бол 1980-2019 онуудад

ХДВ-ийн нийт тархалт 13.09% буюу энэ нь 48-60 сая хүн хепатитын дельта вирусийн халдварт өртсөн гэсэн тооцоолол байна [13].

ДЭМБ-ын зургаан бүс нутагт ХДВ-ийн тархалтын системчилсэн дүн шинжилгээ, мета-анализ хийсэн ба анхдагч үр дүнг HBsAg эерэг болон anti-ХДВ-ийн халдварын дундах ХДВ-РНХ илрүүлэх ПГУ-ын шинжилгээнд үндэслэсэн тооцсон [30]. Хоёрдогч үр дүн нь элэгний хатуурал, элэгний архаг халдвартай HBsAg эерэг хүмүүсийн дунд ХДВ-ийн хүн амын эзлэх хувь хэмжээг тооцоолсон байна [30].



Зураг 5. ХДВ-ийн тархалт. Дэлхий даяар бүх насны ХБВ-ийн халдвартай хүмүүсийн дунд ХДВ халдварын тархалт өндөр байгааг мэдээллэсэн судалгааны газарзүйн байршил, 2008–2017 [2] .

Вирүсийн генетик олон янз байдал, гарал үүсэл нь газар зүйн байршилтай холбоотой бөгөөд өнөөг хүртэл ХДВ-ийн нийт 1-8 хүртэлх генотипд ангилаад байна [31]. ХДВ-ийн генотип нь эмнэлзүйн үр дүнгийн хувьд ялгаатай [2]. Генотип 1 хэлбэр нь дэлхий даяар тархсан бөгөөд халдвар нь хувьсах явцтай байдаг [32]. Европ, Хойд Америк, Төв болон Өмнөд-Хойд Ази, Газар дундын тэнгис, Ойрхи Дорнодод генотип 1 хэлбэр хамгийн их түгэлттэй бол бусад улсад ховор тохиолддог [2, 32]. Генотип 2 хэлбэр нь ихэвчлэн ОХУ-ын Якут муж, Тайвань, Японд бүртгэгдсэн байна [2]. Генотип 2 нь Генотип 1 хэлбэрээс илүү ангижрах чадвартай юм [2]. Генотип 3 хэлбэр нь Амазоны сав газарт түгээмэл тохиолддог (Хүн амын 90% ХДВ-ийн халдвартай) ба фульминант хэлбэрээр Өмнөд Америкийн зүүн хойд хэсгээр халдварлан тархсан [8, 33]. Генотип 4 нь Тайван, Японд бүртгэлттэй [2]. Генотип 5-8 хэлбэр нь Африкын улсууд ба Бразилын уугуул иргэдэд тархсан боловч цагаачдаас үүдэж Европын Англи, Франц, Швейцари гэх мэт улсуудад бүртгэгджээ [2, 32, 33]. Монгол улсын

нийт хүн амын дунд ХДВ-ийн генотип 1 хэлбэр зонхилдог болохыг мэдээлсэн байдаг [34].

1.3. ХЕПАТИТ ДЕЛЬТА ВИРҮСИЙН ОНОШИЛГООНЫ АРГУУД

Хепатит Дельта вирусийг нээж илрүүлснээс хойш удалгүй шууд бус аргаар вирусийн эсрэгбие болон эсрэгтөрөгчийг илрүүлэх ийлдэс судлал мөн шууд аргаар вирус, вирусийн хэсгүүдийг илрүүлэх технологиуд гарч ирсэн ба эдгээр аргууд нь бидний мэдэх уламжлалт оношилгооны технологид хамаарагдана [9]. Эдгээр аргууд нь халдвар авсан болохыг илтгэх боловч вирус идэвхитэй байгаа эсэхийг илэрхийлдэггүй. Иймээс өвөрмөц болон мэдрэг чанар өндөртэй полимеразын гинжин урвал (ПГУ)-д суурилсан технологийг ашиглан вирусийн идэвхижилийг тогтоодог. Эдгээр оношлуурууд нь вирусийг тодорхойлоход шаардлагатай геномыг хурдан олшруулж чаддаг [13].

1.3.1. Серелогийн оношилгооны арга

Одоогийн байдлаар ХДВ-ийг илрүүлэхэд фермент холбоот эсрэгбиеийн урвал (ELISA-enzyme linked immunosorbent assay), радиоиммун шинжилгээ (Radioimmunoassay-RIA) түргэвчилсэн тест (Lateral flow assay/LFA)-ээр вирусийн эсрэгбие (anti-ХДВ)-ийг зэрэг шинжилгээгээр илрүүлж байна.

1.3.1.1. Фермент холбоот эсрэг биеийн урвал (ELISA)

ELISA нь эсрэгбиеийг түргэн хугацаанд шинжилж, хэмжихэд ашиглах ба судлагдаж буй дээжид сонирхсон тодорхой уураг байгаа эсэх, хэрэв байвал хэр хэмжээтэй байгааг тодорхойлдог [35]. Өөрөөр хэлбэл, ELISA нь пептид (уураг, эсрэг бие) гормон гэх мэт бодисуудыг илрүүлэх болон тоо хэмжээг тодорхойлох зорилгоор ашиглагддаг. Энэхүү аргаар дээжид хэр хэмжээний эсрэг бие байгааг эсвэл хэчнээн хэмжээний эсрэгтөрөгч буюу антиген байгааг илрүүлж болно [36]. Учир нь ELISA бичил үүрт Хавтангийн үүрүүдийн гадаргуу тодорхойлохыг хүссэн молекулын эсрэг биеэр бүрхэгдсэн байдаг. ELISA-ийн суурь зарчим нь фермент ашиглан эсрэг бие-эсрэг төрөгчийн холбоог илрүүлэхэд орших ба фермент нь эсрэг биетэй холбогдож өнгөгүй хромоген бодисыг өнгөт бодис болгож, эсрэг бие, антигений холбоо илэрнэ [35, 36].

1.3.1.2. Радиоиммун шинжилгээ (RIA)

RIA нь ийлдэс судлалын эхэн үеийн арга бөгөөд элэгний вирусийг илрүүлэхэд тохиромжтой арга юм. Эсрэг биеийг илрүүлэхийн тулд цацраг идэвхт биш хүйтэн

антиген болон цацраг идэвхтэй материалтай хавсарсан халуун эсрэг биеийг ашигладаг [37]. Зорилтод эсрэг биетэй хүйтэн антиген холбогдох тусам концентраци ихсэж, цацраг идэвхтэй холбогдсон эсрэг биеийн харьцаа буурдаг. Дараа нь эсрэг биетэй холбогдсон эсрэгтөрөгчийг салгаж, супернатантад үлдсэн чөлөөт (холбоогүй) эсрэгтөрөгчийн цацраг идэвхт байдлыг гамма тоолуур ашиглан хэмждэг [37].


1.3.1.3. Түргэвчилсэн оношлуур (LFA)

LFA нь уусмал холимгоос бай молекулыг илрүүлэх, тодорхойлоход зориулсан цаасан дээр суурилсан платформ оношлуур бөгөөд оношилгооны үр дүнг 5-30 минутын дотор гаргадаг. LFA нь полимер мембран дээгүүр бай молекулыг агуулсан шингэн (цус, ийлдэс, сийвэн) капиллярын үзэгдлээр урсгаж нитроцеллюлоз мембран дээр суулгасан баригч молекул тай (эсрэгбие) сонгомлоор харилцан үйлчилж холбогддог [38]. Хэрвээ шинжилгээ хийсэн шингэнд бай молекул байгаа тохиолдолд баригч молекултай холбогдож нитроцеллюлоз мембран дээр өнгөний өөрчлөлт харуулж шинжилгээний үр дүн эерэг гарна. LFA-ийн бүтцэд бай молекул агуулсан шингэнийг дусааж уусгах “дээжийн хэсэг”, бай молекултай сонгомлоор холбогдог шошготой молекулууд (алтны нанопартиклтай холбосон эсрэг бие/IgG-gold, антиген/Ag) агуулсан “нэгдэх хэсэг”, бай молекултой холбогдох чадвартай мембран дээр суулгаж өгсөн молекулын зурвас бүхий (эсрэгбие) “туршилтын шугам” болон “хяналтын шугам”, илүүдэл уусмалыг сорж авдаг “шингээгч хэсэг” болон эдгээрийг нэгтгэн тогтвортой барьж байдаг “суурь материалаас” бүрдэнэ [38].

1.4.2. Молекул оношилгооны арга


ХДВ-ийн нуклейн хүчилд суурилсан молекул оношилгоо, тоон шинжилгээг вирүсийг илрүүлэх болон эмчилгээний үр дүн, явцыг хянахад ашиглаж болдог [39]. ХДВ-ийн геном нь ДНХ биш РНХ-ээс бүтдэг учир ердийн ПГУ-аар илрүүлж болохгүй. Бодит хугацааны полимеразын гинжин урвал (БХ-ПГУ) болон бодит хугацааны тоон урвуу транскриптаза полимеразын гинжин урвал (БХ-тПГУ) нь дээжийг бодит хугацаанд илрүүлэх ба урвуу транскриптаза энзимийн тусламжтайгаар комплементар ДНХ (кДНХ) үүснэ [40]. Улмаар кДНХ дээр праймер, проб (флуоресценц молекул) ашиглан ПГУ явуулснаар хүний цусны дээжид агуулагдаж байсан ХДВ-ийн РНХ тоог гаргадаг. Пробын 5' төгсгөлд флуорофор, 3' төгсгөлд күэнчер олигонуклеотидтой ковалентын холбоогоор холбогдсон байдаг. ПГУ холбогдох шатанд праймер болон пробууд ДНХ-ийн дан гинжин дээр комплементар зарчмаар сууж холбогдоно [40]. Энэ үед полимераза энзим ДНХ-ийн гинжийг

уртасгах явцдаа пробыг задалж флуорофор болон күэнчер харилцан холбоо үгүй болсноор флуорофор нь флуоресценц сигнал өгч төхөөрөмжид хэмжигддэг. Цацаргаж байгаа флуоресценц гэрэл нь уусмал дахь ДНХ-ын хэмжээтэй пропорциональ хэмжээний дохио өгч байдаг. Тиймд БХ-ПГУ-ын цикл бүрд уусмал дахь ДНХ-ийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр флуоресценц сигналын хэмжээ нэмэгдэх бөгөөд энэ сигналыг БХ-ПГУ-ын багаж хэмжиж үр дүнг харуулна [40].



Зураг 6. БХ урвуу транскриптаза ПГУ-ын үе шат

ПГУ-аар эх ДНХ-ийн хэмжээ экспоненциалаар өсдөг. **Зураг 7-д** харагдаж байгаагаар урвал эхлэхэд ДНХ-ийн хэмжээ бага байх тул эхний 1-18 циклд флуоресценц гэрлийн хэмжээ хэт бага байх тул багажид хэмжигдэхгүй [41]. Харин хангалттай хэмжээгээр ДНХ олшроход флуоресценц гэрлийн хэмжээ ихсэж багажид мэдрэгдэнэ. Ингэж багажид хэмжигдэж эхэлсэн циклийн дугаарыг босго цикл (threshold cycle) буюу C_t гэж тэмдэглэдэг [41]. C_t утгаас хамааруулан анхны ПГУ-ын холимогт хэдэн ширхэг эх ДНХ байсныг тооцоолон гаргадаг. Хэрэв анхны холимогт олон эх гинж байсан бол харьцангуй цөөн циклийн дараа флуоресценц гэрэл хэмжигдэж эхлэх тул C_t утга бага харин цөөн эх гинж байсан бол флуоресценц гэрэл олон циклийн дараа хэмжигдэх бөгөөд C_t утга өндөр гарна [41]. БХ-ПГУ-ын үр дүнг чанар (тодорхой ДНХ-ийн дараалал байгаа эсэх) болон тоо, ДНХ-ийн дараалал хэдэн хувь байгаагаар илэрхийлэн гаргах боломжтой [41]. Энгийн ПГУ-тай харьцуулбал хамгийн гол давуу тал нь анхны уусмалд байсан ДНХ-ын тоог өндөр нарийвчлал болон мэдрэг чанартайгаар гаргадагт оршино [41]. Мөн богино дарааллыг олшруулдаг нь агароз гель электрофорез явуулах шаардлагагүй байдгаараа цаг хугацаа хэмнэсэн арга юм [41].



Зураг 7. Бодит хугацааны ПГУ-ын явц

1.4. ЛАМП (LAMP-LOOP MEDIATED ISOTHERMAL AMPLIFICATION) ПОЛИМЕРАЗЫН ГИНЖИН УРВАЛ

1980-аад онд полимеразын гинжин урвал үүсэж хөгжсөнөөс хойш энэхүү генийг олшруулах аргыг эмнэлзүйн хэрэглээнд, ялангуяа генетикийн шинжилгээнд өргөнөөр ашиглах зорилгоор боловсруулсан [42]. Энэхүү оношилгооны арга нь хепатитын халдвар, сүрьеэ, удамшлын өвчин, халдварт өвчин зэргийг илрүүлж, оношлоход тохиромжтой байсан [42]. Тус технологи нь маш өвөрмөц бөгөөд ПГУ-аар нэг сая хувь олшруулсан ДНХ-ийн хэмжээг нэг цагийн дотор тэрбум хувь хүртэл нэмэгдүүлдэг [43]. Түүнчлэн уламжлалт ПГУ-тай харьцуулахад өндөр мэдрэмтгий, тусгай багаж болон мэргэжилтэн шаардахгүй, усан ванн эсвэл дулааны блокийн төхөөрөмж ашиглан хэрэглэж болохуйц, хурдан бөгөөд хялбар хэрэглээтэй технологи юм [10, 44].

1.4.1. ЛАМП-ПГУ-ын ажиллах зарчим

ЛАМП-ПГУ нь Bst ДНХ полимераза энзим болон геном дээрх 6-8 хүртэлх генийн дарааллыг тус тусад нь таних чадвартай 4-6 өөр өөр праймерыг ашиглан изотермийн нөхцөлд нуклейн хүчлийн олшруулалт явуулдаг шинэ технологи юм [10]. Bst ДНХ полимераза энзим нь *Bacillus stearothermophilus* ДНХ Полимераза I-ээс үүдэлтэй. Тус энзим нь 5'-3' ДНХ полимераза энзимийг агуулсан, хэлхээний хүчтэй шилжилт хөдөлгөөнтэй. Хэлхээний хүчтэй шилжилтийн идэвхжил нь Bst ДНХ полимеразыг тогтмол температурт ДНХ нийлэгжүүлэх боломжийг олгодог [42]. ЛАМП-ПГУ-ын урвалын явц болон үр дүнг шийдвэрлэх чухал элемент нь праймер загварчлал байдаг учир праймеруудыг зөв зохиох нь хамгийн нарийн чухал байдаг [42]. Праймеруудын хослолыг нуклеотидын байршил, хоорондын зай, концентраци


гэх зэрэг зүйлсийн хүрээнд оновчтой болгох шаардлагатай[10]. ЛАМП-ПГУ-д FIP (шууд дотоод праймер), VIP (урвуу дотоод праймер), F3 (шууд праймер) болон B3 (урвуу праймер) гэсэн 4 үндсэн праймер болон нэмэлт LP, LB гэх хоёр гогцоот праймерыг хэрэглэдэг [45]. Нэмэлт праймеруудыг хийж өгснөөр урвалыг хурдасгах боломжтой болно [10]. FIP праймер нь геномын комплементар F1 болон F2 бүсийн нуклеотидоос бүрдэх бол VIP праймер нь комплементар B2 болон B1 бүсийн нуклеотидоос бүрддэг [10, 42]. Харин LF гогцоот праймер нь F1 болон F2 бүсийн дунд, LB гогцоот праймер нь B1 болон B2 бүсийн дунд байрлана [10, 42] .

1.4.2. ЛАМП-ПГУ-ын үе шат

1-р шат. FIP праймер нь зорилтод ДНХ-ийн F2 бүс дээр сууснаар кДНХ синтезлэгдэж ПГУ эхэлнэ. Дараагаар нь F3 праймер ДНХ-ийн утаслаг дээр суух ба ДНХ полимераза энзим нь праймерыг уртасгадаг [42]. F3 праймер уртсах үедээ FIP праймертай холбогдсон кДНХ утаслагыг шахан холдуулж 5' төгсгөлд FIP праймер өөр дээрээ сууж гогцоот бүтцийг (self-hybridizing loop structure) үүсгэдэг [10]. Энэ хэлхээ нь VIP праймер кДНХ синтезийг эхлүүлэх суурь болох ба VIP праймер 5' төгсгөл дээр үүссэн FIP праймерын гогцоог нээж уртасна. B3 праймер кДНХ-д сууж холбогдсоноор ДНХ-ийн 3' төгсгөл дээр нуклеотид нэмэгдэж ДНХ-ийн анхдагч дамббелл (dumbbell) гогцоот бүтэц үүснэ [42] .

2-р шат. Анхдагч дамббелл бүтэц нь ПГУ-ын дараагийн шат буюу элонгацийн үеийг эхлүүлдэг [42]. Энэ шатанд FIP праймер дамббелл бүтцийн гогцоонд сууж, кДНХ синтезийг эхлүүлж улмаар F1 праймер уртсаж 3' төгсгөлд шинэ гогцоо үүсгэдэг. FIP праймераар ДНХ олшруулалт давтагдах тусам дамббелл бүтэц бий болсоор байдаг [10]. Эдгээр праймерын үе шатууд нь VIP праймерын хувьд ч ялгаагүй ижил юм. ЛАМП-ПГУ-ын бүтээгдэхүүнийг өвөрмөц бус бодис, булингар зэрэг шууд бус аргуудаар илрүүлж болдог [42] . ЛАМП-ПГУ-ыг энгийн ПГУ-тай харьцуулбал өндөр мэдрэмтгий, хялбар бөгөөд зардал багатай, тогтмол 60°C–65°C -д 1 цагийн дотор урвалыг явуулж дуусгадаг онцлог давуу талтай юм [10, 42, 46]. Гэвч праймер загварчлал болон урвалаар дамжих бохирдол нь санаа зовоосон асуудал хэвээр байна [10]. ПГУ-ын урвалын бүтээгдэхүүнийг төгсгөлөг цэг (end point), агароз гель электрофорез, кальцин, малахит ногоон болон гидроксинафтол хөх зэрэг янз бүрийн аргаар шалгаж болно. Кальцин гидроксинафтол хөх зэрэг бодисуудыг ПГУ-ын бүтээгдэхүүнд нэмж өгөх үед тубны тагийг нээх тул бохирдох эрсдэлтэй байдаг. ЛАМП-ПГУ-ын арга зүйгээр аюултай өвчин үүсгэгчид болох SARS-CoV, Чикунгунья, Денге вирусүүдийг илрүүлэх технологийн

хөгжүүлэлт аль хэдийн хийгдчихсэн бол урвуу транскриптазын ЛАМП (RT-LAMP) шинжилгээгээр Шүлхийн вирус, Зика вирус, Томуугийн вирус, Цитомегаловирус (CMV), Хүний папилломавирус (HPV), Херпес (HSV)-ийн вирусүүдийг илрүүлээд байна [46].




Зураг 8. ЛАМП полимеразын гинжин урвалын үе шат, механизм [14]

1.4.3. Колориметрик буюу өнгө үзүүлэгч ЛАМП полимеразын гинжин урвал

Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ нь дээжид тодорхой хэмжээний ДНХ эсвэл РНХ-ийн дарааллыг хурдан бөгөөд мэдрэмтгий илрүүлэх боломжийг олгодог нуклейн хүчлийн олшруулах арга юм [11]. Богино хугацаанд их хэмжээний нуклейн хүчлийг үүсгэдэг бөгөөд үүссэн ДНХ-ийн бүтээгдэхүүнийг колориметрийн индикатор ашиглан хялбархан харж болно [11]. ЛАМП-ПГУ-ын үндсэн зарчим нь тогтмол температурт зорилтот нуклейн хүчлийн дарааллыг олшруулдаг тусгайлан


боловсруулсан праймер ба ДНХ полимеразыг ашиглах явдал юм [11]. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-д рН-мэдрэмтгий будаг фенол улаан эсвэл крезолын улаан гэх мэт бодисууд урвалын холимогт ордог. Фенол улаан бодис нь агаарт тогтвортой, талс бүтэцтэй бөгөөд өнгө нь улаан (570 нм)-аас шар (443 нм)-руу аажмаар шилждэг [47]. Урвал явагдахад өнгө нь улаанаас шар болж өөрчлөгддөг нь нуклейн хүчил олширсныг илтгэнэ [47]. Өнгөний өөрчлөлтийг тусгай багаж төхөөрөмж ашиглахгүйгээр энгийн нүдээр ажиглаж болох бөгөөд энэ аргыг лабораторийн хязгаарлагдмал орчинд ашиглахад тохиромжтой [47]. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ нь халдварт өвчин, удамшлын эмгэг, хоол хүнсээр дамжих эмгэг төрүүлэгчдийг илрүүлэх зэрэг олон боломжит хэрэглээтэй.



Зураг 9. Өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ын схем

1.4.4. Флуоресценц ЛАМП-ПГУ полимеразын гинжин урвал

Флуоресценц ЛАМП-ПГУ нь дээжид байгаа тодорхой хэмжээний ДНХ эсвэл РНХ-ийг илрүүлэхийн тулд урвалын бүтээгдэхүүнтэй холбогддог флуоресценц будагч бодис ашиглан нуклейн хүчлийг олшруулдаг арга юм [45]. Энэ аргыг флуоресценц ЛАМП эсвэл бодит цагийн ЛАМП-ПГУ гэж нэрлэдэг [45]. Флуоресценц ЛАМП-ПГУ нь зарчмын хувьд өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-тай адил тусгайлан боловсруулсан праймер болон ДНХ полимераза энзимийг ашиглан нуклейн хүчлийг олшруулна [45]. Нуклейн хүчлийн олшруулах урвал явагдах үед флуоресцент будаг нь флуорометр гэх мэт тусгай тоног төхөөрөмж ашиглан бодит цагийн хугацаанд хэмжиж болох дохиог ялгаруулдаг [46]. Үүссэн флуоресценц гэрлийн хэмжээ нь дээжид агуулагдах олшруулсан нуклейн хүчлийн хэмжээтэй шууд пропорциональ бөгөөд зорилтот ДНХ болон РНХ-ийн дарааллын тоон шинжилгээг хийх боломжийг олгодог [46]. FAM (6-carboxyfluorescein) флуоресценц будгийг ЛАМП-ПГУ-д ашиглах ба өдөөх долгионы урт нь ойролцоогоор 494 нм, цацрагийн хамгийн их долгионы урт нь ойролцоогоор 521 нм байна [48].



Зураг 10. Флуоресценц ЛАМП-ПГУ-ын схем

1.4.5. ЛАМП-ПГУ-ын хязгаарлагдмал тал

ЛАМП-ПГУ-ын чухал хязгаарлалтуудын нэг нь өвөрмөц бус бүтээгдэхүүний олшруулалт явагдаж улмаар хуурамч эерэг (false positive) үр дүн бий болгох явдал юм. Бага хэмжээний зорилтот ДНХ/РНХ дарааллыг илрүүлэх эсвэл их дэвсгэр ДНХ (high background DNA) байгаа тохиолдолд ашиглахад төвөгтэй байдаг [11, 42]. Мөн тоолох чадамж хязгаарлагдмал юм. ЛАМП-ПГУ-ын олшруулсан бүтээгдэхүүний хэмжээ нь зорилтот ДНХ/РНХ-ийн дарааллын анхны концентрацаас хамаардаг боловч дээжид буй зорилтот нуклейн хүчлийн дарааллын хэмжээг шууд хэмжих боломжгүй [11, 14, 42].

Түүнчлэн ЛАМП-ПГУ нь бусад ПГУ-ын аргуудтай адил өргөн хэрэглэгддэггүй. Учир нь тус технологийн арга зүй нь тодорхой праймер шаарддаг бөгөөд зорилтот дараалал бүрд урвалын нөхцөлийг сайтар оновчтой болгох шаардлагатай байдаг [42]. Олшруулалтын дараах салгах үе шат байхгүй тул бохирдолд илүү өртөмтгий байх магадлал тур өндөр юм [42].

Гэвч дээрх хязгаарлалтуудыг үл харгалзан ЛАМП-ПГУ нь нуклейн хүчлийг хурдан бөгөөд мэдрэмтгий олшруулах, ялангуяа нөөцийн хязгаарлагдмал орчинд эсвэл тусламж үйлчилгээний цэгийн шинжилгээнд зориулагдсан хүчирхэг бөгөөд ирээдүйтэй хэрэгсэл юм [14, 42].

БҮЛЭГ 2. ТУРШИЛТЫН ХЭСЭГ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ

2.1.1. Судалгааны ёс зүйн зөвшөөрөл

Эрүүл мэндийн яам, анагаахын ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн 243 дахь тогтоолоор баталгаажсан (**Хавсралт 1**).

2.1.2. Судалгааны дээж

Судалгаанд ашиглах дээжийг “Элэгний төв” эмнэлгийн клиникийн лабораторид авсан ба Хепатитын Дельта вирусийг илрүүлэх БХ-ПГУ шинжилгээгээр ХДВ халдвартай 35-40 насны 8 хүн (3 эмэгтэй, 5 эрэгтэй), халдваргүй буюу эрүүл 20-24 насны 15 (8 эмэгтэй, 7 эрэгтэй) хүний цусны ийлдсийг ашиглаж нийт 23 хүний дээж дээр уг судалгааг хийв.

2.1.3. Химийн бодисууд

EDTA	Biosesang
Orange G	Sigma-Aldrich
Tris	Sigma-Aldrich
Агароз	Lonza
Глицерол	Sigma-Aldrich
ДНХ маркер	Invitrogen
Борийн хүчил	Sigma-Aldrich
Этидиумбромид	Sigma-Aldrich
HCl	Sigma-Aldrich

2.1.4. Буффер, уусмал

2.1.4.1. Агароз гель электрофорез

TBE буффер x10	Трис-HCl (pH=7.5)	890 mM
	Борийн хүчил	890 mM
	EDTA	20 mM
6 x глицерол лоадинг буффер	Трис-HCl (pH=7.5)	10 mM
	EDTA (pH=8)	10 mM
	Orange G	0.025%
	Глицерол	70%

2.1.5. Судалгаанд ашигласан цомгууд

BioActGene®	Virus Purification Kit
NEB	WarmStart® Colorimetric LAMP 2X Master Mix
NEB	WarmStart® LAMP Kit

2.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.2.1. ХДВ-ийн геномын дарааллын анализ

ХДВ-ийн нуклейн хүчлийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын технологийн арга зүйг боловсруулахын тулд ХДВ-ийн генийн дараалал буюу геном дээр ЛАМП-ПГУ-ын полимержуулах урвалыг явуулах боломжтой гомолог өндөр дарааллын бүсийг тодорхойлсон. Үүний тулд ХДВ-ийн одоогоор мэдэгдэж буй нийт 8 генотипийн геномын дарааллыг хооронд нь харьцуулж хамгийн бага ялгаатай дарааллыг сонгон авав.

2.2.2. ЛАМП-ПГУ-ын праймер боловсруулалт

ЛАМП-ПГУ-ын багц праймерыг зориулалтын программ (NEB® LAMP Primer Design Tool) ашиглан зохиов.

2.2.3. ХДВ-ийн нуклейн хүчил ялгах

“Bioactiva diagnostica GmbH” компанийн BioActGene® Virus Purification цомог ашиглан зааврын дагуу РНХ ялгав.

Карьер РНХ агуулсан 600 мкл лизис буфферийг лизис тюрб-д хийж дээр нь 150 мкл дээжийг мөн 20 мкл протейназа К уусмалыг нэмж пипетикээр эсвэл вортекс ашиглан сайтар холино. Үүний дараа 70°C-д, 5 мин инкубацилна. 2000× *g*-д 1 мин орчим спин хийж тюрбний таг дээрх дуслуудыг доош унагаана. Лизат дээр 600 мкл 96-100%-ийн этанол нэмж 8000× *g*-д 1 мин центрифугдэнэ. Лизатаас 680 мкл-ийг болгоомжтойгоор авч мембран фильтр бүхий багана руу зөөвөрлөж, 8000× *g*-д 1 мин центрифугдэнэ. Мембран фильтрийг шинэ баганад суурилуулж үлдэгдэл лизатыг нэмж, 8000× *g*-д 1 мин центрифугдэнэ. Мембран фильтрийг дахин шинэ баганад суурилуулж 500 мкл угаах 1 буффер нэмж, 8000× *g*-д 1 мин центрифугдэнэ. Мембран фильтрийг шинэ баганад суурилуулж 600 мкл угаах 2 буффер нэмж, 8000× *g*-д 1 мин центрифугдэнэ. Мембран фильтрийг дахин шинэ баганад суурилуулж 200 мкл угаах 2 буффер нэмж, 11000× *g*-д 3 мин центрифугдэнэ. Мембран фильтрийг элюцийн тюрбд шилжүүлж 56°C-д 15 мин этанолыг ууршуулах зорилгоор тагийг нээлттэйгээр инкубацилна. Дараа нь 50 мкл усыг мембраны төв рүү буудан хийж 1-2 мин инкубацилна. Усыг 70°C-д урьдчилан халаасан байна.

Инкубаци дууссаны дараа 11000× *g*-д 1 мин центрифугдэнэ. Вирусээс ялгасан РНХ-ийг -80°C-д хадгална.

2.2.4. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ

Хепатитын Дельта вирусийн халдварыг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулахын тулд, БХ-ПГУ-тай харьцуулж, баталгаажуулна. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын праймер болон пробыг **Хүснэгт 7** -д үзүүлэв.

Хүснэгт 4. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын праймер болог пробын дараалал

Шууд праймер ХДВ-F	5'-GGCWCTCCCTTAGCCATCCG-3'
Урвуу праймер ХДВ-R	5'-GGTCGGCATGGCATCTCCA-3'
Проб	6FAM-CTCCTWCGGATGCCAGGTCGGAC-BHQ1

“Bio-Rad” компанийн iTaq™ Universal Probes One-Step цомог болон Agilent Technologies Stratagene Mx3005p циклер багажийг ашиглан БХ-ПГУ-ын ажлыг хийж гүйцэтгэсэн. БХ-ПГУ-аар вирусийн тоолох шинжилгээг хийхдээ ДЭМБ-аас баталж гаргасан ХДВ-ийн стандартуудыг ашиглав (**Хавсралт 2**).

Хүснэгт 5. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын мастер холимог

Урвалж	Хэмжээ
2x буффер	12.5 мкл
Шууд праймер	1 мкл (10 пкмоль)
Урвуу праймер	1 мкл (10 пкмоль)
Проб	1 мкл (10 пкмоль)
Урвуу транскриптаза энзим	0.5 мкл
РНХ	9 мкл
Нийт эзлэхүүн	25 мкл

Хүснэгт 6. ХДВ-ийг илрүүлэх БХ-ПГУ-ын нөхцөл

ПГУ-ын алхамууд	Мөчлөг	Температур	Хугацаа
Урвуу транскриптаза	1	50°C	20 мин
Денатураци	1	95°C	3 мин
Аннелинг ба экстенци	40	95°C	15 сек
		60°C	60 сек

2.2.5. ХДВ-ийг илрүүлэх ЛАМП-ПГУ-ын арга зүйг боловсруулах

2.2.5.1. Колориметрик буюу өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ

“New England Biolabs” компанийн WarmStart® Colorimetric LAMP 2X Master Mix цомог ашиглан болон ХДВ-ийг илрүүлэх өнгө үзүүлэгч ЛАМП-ПГУ-ын туршилтын ажлыг гүйцэтгэв. **Хүснэгт 10** болон **Хүснэгт 11** -ийн дагуу урвалж, уусмалуудыг бэлтгэж 1 цагийн турш 65°C-д инкубацлав.

Хүснэгт 7. ЛАМП-ПГУ-ын праймеруудын холимог

Урвалж	Хэмжээ
ХДВ-F3	2 мкл (0,2 мкмоль)
ХДВ-B3	2 мкл (0,2 мкмоль)
ХДВ-FIP	16 мкл (1,6 мкмоль)
ХДВ-BIP	16 мкл (1,6 мкмоль)
ХДВ-LF	4 мкл (0,4 мкмоль)
ХДВ-LB	4 мкл (0,4 мкмоль)
Молекул биологийн ус	56 мкл
Нийт эзлэхүүн	100 мкл

Хүснэгт 8. ХДВ-ийг илрүүлэх өнгө үзүүлэх ЛАМП-ПГУ-ын мастер холимог

Урвалж	Хэмжээ
2x буффер	10 мкл
Праймеруудын холимог	мастер 2 мкл
Молекул биологийн ус	5 мкл
РНХ	3 мкл
Нийт эзлэхүүн	20 мкл

2.2.5.2. Флуоресценц ЛАМП-ПГУ

“New England Biolabs” компанийн WarmStart® LAMP Kit болон бодит цагийн ПГУ-ын багаж дахь FAM болон SYBR® сувгаар ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын туршилтыг гүйцэтгэсэн. **Хүснэгт 12** -ийн дагуу флуоресценц ЛАМП-ПГУ-ын урвалжуудыг холимогуудыг хийж, **Хүснэгт 13** -ийн нөхцөлөөр Agilent Technologies Stratagene Mx3005p циклер багажийг ашиглан туршилтыг гүйцэтгэв.

Хүснэгт 9. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын мастер холимог

Урвалж	Хэмжээ
2x буффер	10 мкл
Праймеруудын мастер холимог	2 мкл
Флоуресценц будаг	0.4 мкл
Молекул биологийн ус	4.6 мкл
РНХ	3 мкл
Нийт эзлэхүүн	20 мкл

Хүснэгт 10. ХДВ-ийг илрүүлэх флуоресценц ЛАМП-ПГУ-ын нөхцөл

ПГУ-ын алхамууд	Мөчлөг	Температур	Хугацаа
Пре денатураци		68°C	20 мин
Денатураци	50	68°C	30 сек
Аннелинг ба экстенци		68°C	20 сек
	(Дата цуглуулах)		
	1	95°C	60 сек
Хайлах муруйн шат	1	55°C	30 сек
	1	95°C	30 сек

2.2.6. Агароз гель электрофорез

